

**Манжийн Хууль зүйлийн бичиг, Монгол Улсын
Хууль зүйлийн бичгийн харьцуулсан судалгаа**

**A Comparatives Study of the Manchu Legal Code
and the Jarliy-iyar toytaγaysan mongyol ulus-un
qauli jüil-ün bičig (The Law of Mongolia
enacted by Bogd Khan's Edict /1911-1919/)**

Баянбаатарын Батбаяр

<https://orcid.org/0009-0006-9902-0600>

Хууль зүйн ухааны доктор (Ph.D.).

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн

Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш,

Улаанбаатар хот, Монгол Улс.

batbayar_b@num.edu.mn

© B.Batbayar, 2025



[Attribution-NonCommercial 4.0 International
\(CC BY-NC 4.0\)](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)

[Товч утга]

Тус өгүүлэлд “Манжийн Хууль зүйлийн бичиг” болон “Монгол Улсын Хууль зүйлийн бичиг”-ийг харьцуулан судлав. Монголчууд “Монгол Улсын Хууль зүйлийн бичиг”-ийг боловсруулахдаа “Манжийн Хууль зүйлийн бичиг”-ийн агуулгыг төдийлөн харгалзаагүй, харин хэлбэрийн буюу хууль зүйн техникийг чадамгай ашиглажээ. Ингэхдээ Монгол Улс нь бие даасан, тусгаар улсын хувьд уламжлалт онцлогоо түлхүү харгалзахаас гадна нийгмийн харилцааг зохицуулах хэм хэмжээг өөрийн улс төр, нийгэм, эдийн засаг, ахуй байдалд нийцүүлэн боловсруулсныг харьцуулсан судалгааны үр дүн харуулж байна. Монгол Улсын Хууль зүйлийн бичгийн 65 дэвтрээс 30 дэвтрийг шинээр боловсруулсан бол 34 дэвтрийг Манжийн Хууль зүйлийн бичгийн техникт тулгуурлан ихээхэн өөрчлөн найруулжээ. Харин цөөн зарим зүйл заалтыг хэвээр авч ашигласан байна.

[Түлхүүр үг]

Манжийн Хууль зүйлийн бичиг, Монгол Улсын Хууль зүйлийн бичиг, хэлбэрийн харьцуулалт, агуулгын харьцуулалт, харьцуулсан судалгаа.

I. Оршил

Монголын эрх зүйн түүхнээ “Хууль зүйлийн бичиг” гэх нэртэй хоёр хууль гол байр суурь эзэлдэг. Нэг нь манжийн эрхшээлийн үед Монголын нийгмийн харилцааг зохицуулж байсан “Зарлигаар тогтоосон гадаад монголын төрийг засах явдлын яамны Хууль зүйлийн бичиг” /цаашид “Манжийн ХЗБ”, зарим тохиолдолд “ЗТГМТЗЯЯХЗБ” гэж товчилно./, нөгөө нь сэргэн мандсан Монгол Улсын үед үйлчилж байсан “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” /цаашид “МУХЗБ” гэж товчилно./ юм. Тус хоёр хуулийн харьцуулсан судалгааг өдгөө хүртэл хийгээгүй байна. Ер нь Манжийн үеийн бусад хуулиудыг ч өөр хооронд нь харьцуулан судалсан нь бараг үгүй. Цаашид нягтлан судлууштай юм. Энэ өгүүлэлд Манжийн ХЗБ болон МУХЗБ-ийг харьцуулан судалж тодорхой дүгнэлт саналыг дэвшүүлэх болно. Ийнхүү харьцуулан судлах нь нэг талаар эдгээр хуулийн нийтлэг ба ялгаатай тал, хоорондын холбоо хамаарал хийгээд зарим судлаачдын дүгнэсэнчлэн МУХЗБ нь Манжийн ХЗБ-ийн хуулбар мөн эсэхийг тодруулахад чухал ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл тусгаар тогтносон бүрэн эрхт Монгол Улс тухайн үед харь улсын хуулийг хуулбарлан нийгмийн харилцаагаа зохицуулж байсан эсэхийг зайлшгүй авч үзэх шаардлага бий. Эндээс Хууль зүйлийн бичгийн судалгааны хүрээнд дотоод, гадаадын зарим эрдэмтдийн дэвшүүлсэн үнэлэлт дүгнэлтийг эргэн нягтлах шаардлагатай юм.

II. Манжийн эрхшээлийн үеийн зарим хууль цааз, онцлогийн тухайд товчхон

Манжийн эрхшээлийн үед Монголын эрх зүйд ихээхэн өвөрмөц онцлог байдал тогтсон байв. Үүнд юуны өмнө Манж нар эрхшээл захиргаандаа оруулсан монголчуудыг, ялангуяа босоо харилцаа буюу төр, иргэний хоорондын харилцааг өөрсдийн тогтоосон хууль цаазаар журамлахаар болж, үүний хүрээнд Монгол цаазын бичиг, Шүүх цаазын бичиг, ЗТГМТЗЯЯХЗБ зэрэг томоохон хуулиудыг дагаж шийтгүүлжээ. Монголд зориулсан Манжийн анхны хуулиуд 1630-аад оны дунд үеэс эхэлж батлагдан гарч, хожим хэд хэдэн удаа өөрчлөлт, нэмэлт орж шинэчлэгдсэн байдаг. Эдээр хуулиуд нь Монголын уламжлалт хууль цаазад тулгуурласан шинжтэй. Харин Монгол цаазын бичиг хэмээх хууль нь олон удаагийн нэмэлт, өөрчлөлтийг дамжсаар 1795 онд батлагдсан бол ГМТЗЯЯХЗБ нь 1789 онд батлагдаж, 1811/1815, 1821-1840 оныг дамжин, хамгийн сүүлд 1890 онд нэмэлт, өөрчлөлт оруулж шинэчлэн батлагдсан байна. Олон жилийн турш нэмэлт засвар оруулж байснаас хуулиудын заалт хоорондоо зөрчилдөх болсныг

Гадаад монголын төрийг засах явдлын яам зөвшөөрөн хүлээхэд хүрч байсныг¹ судлаачид бүтээлдээ тэмдэглэсэн нь бий. Тус хоёр цаазын бичгийн олон янзын эх бичиг, хуулбар эх, хувилбар эхүүд бий бөгөөд эдгээрийг нарийвчлан судлах шаардлагатай. Дурдсан цаазын бичгүүдийн аль аль нь Монгол хуулийн уламжлалд суурилсныг судлаачид дүгнэсэн хэдий ч цаашид нарийвчлан судлууштай, өөрөөр хэлбэл, чухам юуг уламжлан авсан бэ гэдгийг тодорхой гаргах нь чухал юм.

Өгүүлэлд харьцуулан авч үзэж буй ГМТЗЯЯХЗБ нь 63 дэвтэр, 1544 зүйлээс бүрдэнэ. Агуулгын хувьд гадаад Монголын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь, угсаа залгамжлах ёс, зэрэг хэргэм, цалин пүнлүү, цэрэг, гааль, санхүү, ёслол, гэр бүл, өртөө, лам нар, эрүү, иргэн, гадаад харилцаанд холбогдох нийт 63 дэвтэрт төрөлжүүлэн нэгтгэжээ. Үүнд нэг талаас Юань гүрний үеийн монгол хаадын тогтоон мөрдүүлсэн олон зүйл хууль тогтоомжийг системчилж ирсэн тэр уламжлалыг, мөн 1600-аад оны эхэн үеэс хууль тогтоомжийн төрөлжүүлэлт монгол уламжлалт хууль цаазад эхлэлийн төдий байсныг үргэлжлүүлж Манж нар шууд хүлээн авч хэрэгжүүлсэн, нөгөө талаас дорно дахины эрх зүйн соёл зохих ёсоор нөлөөлсөн гэж үзүүштэй. Манжийн төрөөс тогтоосон хууль цаазуудыг монголчууд тодорхой цаг хугацааны хүрээнд даган мөрдөж байсан нь түүхэн үнэн, ийм ч учраас Манжийн төрөөс Монголд зориулж баталсан дурдсан хууль цаазуудыг монголын эрх зүйн түүхнээ хамааруулан авч үзсээр ирсэн нь нийтлэг юм.

Энэ үеийн дараагийн нэг онцлог бол монголчууд ахуй, иргэний харилцаанд холбогдох асуудлыг өөрсдийн тогтоон шийтгэсэн хуулийн хүрээнд явуулахаар журамласан явдал болно. Манжийн төрд үнэндээ олон мянганы турш амьдрал практикаар шалгагдаж, нэгэнт тогтворшсон монголчуудын зан заншил, дотоод амьдралын харилцааг зохицуулж буй хэм хэмжээг шууд хүч тулган өөрчлөх боломж байгаагүй бөгөөд жам ёсны түүхэн энэ нөхцөлийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байв. Тийм ч учраас халхын олон хошуудад удаа дараа тогтоосон цаазуудыг тогтоох хийгээд хүчин төгөлдөр дагаж мөрдөхөд нь хөндлөнгөөс огт оролцоогүй юм. Эдгээр хууль цаазын зарим хэм хэмжээ миний олж тогтоосноор лавтайяа 1923 он хүртэл тодорхой хүрээнд үйлчилсэн бөгөөд нийгмийн хөгжлийн шаардлагаар өөрөө аяндаа үйлчлэл нь зогссон бол зарим хэм хэмжээ нь албан ёсоор хүчингүй² болжээ. Халх журам бол нэгдмэл нэг хууль

¹ Содовсүрэн, Б. Хувьсгалын өмнөх Монголын төр ба хууль цааз (1911-1920). Уб., 1989. 20 дахь тал.

² Тухайлбал, энэ тухай нотолгоог дараах архивын эх сурвалжаас үзэх боломжтой. Баримтыг танилцуулбал: *“Олноо өргөгдсөний арван гуравдугаар он (1923), арван*

биш, халхын өөр өөр хошуудад, өөр өөр цаг хугацаанд монгол ноёдын чуулганаар хэлэлцэн баталсан олон тусдаа бие даасан хууль байсан бөгөөд хожим эмхэтгэж нэгтгэсэн юм. Дотоод системчлэлээс нь харвал урьд өмнөх уламжлалт хуулиудтай харьцуулахад харьцангуй дэвшилтэй болсон нь ажиглагддаг. Тухайлбал, хууль зүйн техникийн хувьд зүйл хуваасан байхаас гадна тухайн зүйл бүрд ойролцоо төрлийн харилцааг аль болох нэг дор байршуулсан байгаагаас мэдэж болно.

III. Монгол Улсын Хууль зүйлийн бичгийн тухайд товчхон

МУХЗБ бол XX зууны эхэн үеийн монголын эрх зүйн үндсэн гол эх сурвалж мөн. МУХЗБ нь нийгмийн олон талт асуудлыг багтаасан буюу эрхийн хэм хэмжээний бараг бүх салбарыг хамруулсан, төрөлжүүлэн хуульчилсан 65 дэвтрээс бүрдэх ба тухайн үеийнхээ нийгмийн харилцааг зохицуулж буй хэм хэмжээний эрх зүйн үндсийг тодорхойлсон, зарчмын гол гол хэм хэмжээг тусгасан, Засаг захиргаа, Төрийн алба, түшмэл ёс, Төрийн байгуулал, Хааны эрх хэмжээ, Хүү сан, Татвар гааль, Иргэн, Гэр бүл хийгээд Цэргийн хэргийн хууль, Лам нарын хэргийн хууль, Эрүүгийн хууль гэх мэт тухайн үеийн нийгмийн харилцааны ихэнх салбарыг хамарсан, тэдгээрийг зохицуулах хэм хэмжээг тусгасан, шинэ хэм хэмжээгээр баяжигдан боловсрогдож, төрийн байгууллага (Төрийн тэргүүн, Засгийн газар, Улсын хурал, олон яамд)-ын хууль тогтоох үйл ажиллагааны үр дүнд дэвтэр (эрх зүйн салбар) тус бүрээр батлагдан гарч, системчлэгджээ. Үүнд нэг талаар Манжийн ХЗБ гадаад хэлбэрийн хувьд зохих нөлөө үзүүлснийг дурдах хэрэгтэй.

ЗТГМТЗЯЯХЗБ нь хожим сэргэн мандсан Монгол Улсын нийгмийн харилцааг зохицуулж байсан МУХЗБ-тэй хэлбэрийн хувьд

хоёр сарын хорин таван бөгөөд европын нэгэн сарын гучин нэгний өдөр Ардын засгийн газраа хурлын олон гишүүд хуралдаж зөвлөлдөн тогтоосон тавин тавдугаар хурлын бичиг. ... Гуравдугаар зүйл. Үүний урьд Ардын засгийн Шүүх явдлын яамнаас Нийслэл хүрээний Эрдэнэ шанзудба нараас харьяат Шавийн дотор урьд тогтоосон Халх журам хэмээх хуучин бичгээс шавь дангаар холбогдсон бага сага ял хэрэгт анз ес, анз тав, их бага хөл хэмээхээр баглаж шийтгэн явсан нь одоо эл ёсны учир дагаж шийтгэвээс нийлэлцэх эсэхийг тогтоон заахыг эрсэн учраа энэ мэт дан гагц Их шавийн дотор баглаж шийтгэхийг нь зогсоож зориуд тогтоосон хууль дүрэм хэргийн ёсоор олон аймгуудын нэгэн адил мөрдөн дагаж явуулбаас болох эсэхийг тогтоому хэмээн ирсэн тухайд манай Засгийн газраас эл хэргийн сайтар шүүмжлэн хэлэлцэж хэрхвээс зохих саналыг илтгэн гаргаж ирүүлээд тогтоон шийтгүүлээр зохих газраа явуулжээ. Эдүгээ Ардын намын Төв хорооноос уг хэргийг тус хурлын есдүгээр зүйлд хэлэлцээд эл хэргийг Шүүх яамны төлөвлөсөн ёсоор зориуд тогтоосон хууль дүрэм хэргийн ёсоор мөрдөн дагаж явуулбаас зүйтэй болов уу хэмээн хэлэлцсэн учрыг гаргаж гүйцэтгэн шийтгэмү хэмээн ирснийг хэлэлцээд ёсоор болгон баталж Шүүх яамнаас эрхлэн гүйцэтгэхээр тогтов.” МУУТА, Х-1, Д-1, Хн 290. 48-49.

ихээхэн төстэй, зарим эрдэмтдийн бичсэнчлэн агуулгын хувьд ч ихэнх нь давхцдаг³. Иймд хэлбэр, агуулгын хүрээнд дор харьцуулан авч үзье.

IV. Манж, Монгол Хууль зүйлийн бичгийн хэлбэрийн харьцуулалт

Зарим судлаачид МУХЗБ-ийг Манжийн ХЗБ-ийн хуулбар⁴ гэх буюу монгол хууль биш гэж үздэг. Мөн МУХЗБ нь бие даасан тусгаар улсын хууль мөн эсэхэд ихээхэн эргэлздэг. Иймд МУХЗБ-ийг Манжийн ГМТЗЯЯХЗБ-тэй харьцуулах нь дээрх асуудалд тодорхой хариулт өгөхөөс гадна хууль тогтоомжийн системчлэлийн хүрээнд монголчууд тус хуулийг өөрсдөө боловсруулан, хууль тогтоох үйл ажиллагааны хүрээнд кодификацжуулж, нийгмийн өргөн хүрээний харилцааг зохицуулсан нэгдмэл төрөлжүүлсэн хууль бий болгох зорилгоор батлан тогтоосныг тодруулахад чухал ач холбогдолтой. Түүнчлэн нөгөө талаас энэ хууль нь Монгол Улс тусгаар тогтносон бие даасан улс байсны бас нэг гол нотолгоо болохыг харьцуулалтын үр дүнгээс харах боломжтой.

Судлаачдын бүтээлээс үзвэл тус хоёр ХЗБ-ийг ерөнхий агуулгын хүрээнд харьцуулан үнэлэлт дүгнэлт өгсөн нь нийтлэг ажээ. Тухайлбал, доктор Б.Содовсүрэн МУХЗБ-ийн ерөнхий агуулгын тухайд нарийвчлан дурдаж, зарим дэвтрийг харьцуулсны үндсэн дээр ...манжийн хуулиар тогтоосон зарим хэм хэмжээг өөрчилсөн нь хэлбэрийн шинжтэй ч манжийн үеийн хуулийг халсан ач холбогдолтой арга хэмжээ болсон байна⁵ хэмээн оновчтой дүгнэжээ. Харин доктор Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нар энэ хуулийн ...51 дэвтэр бүхэлдээ Манжийн хуучин хуулийн заалтыг монгол төрийн уламжлал, онцлогийг харгалзан найруулан зассан шинжтэй байна⁶ гэж дүгнэсэн байдаг. Түүхч, хуульч эрдэмтэд энэ дүгнэлтийг өөр өөрсдийн бүтээлд өнөөг хүртэл улируулан эшлэсээр байна.

Энд харьцуулан судалж буй Манжийн ХЗБ нь “Уг айлтгал”-аас гадна 63 дэвтэр, 1544 зүйлээс бүрдэнэ. МУХЗБ-ээс ялгаатай нь гадаад засаг буюу Халхын 4 аймаг, 150 хошуу, дотоод засаг буюу Өвөрмонголын 6 чуулган, 49 хошууны нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын асуудлыг ялгамжтай байдлаар зохицуулж,

³ Болдбаатар, Ж., Лүндээжанцан Д. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Нэмж засварласан гурав дахь хэвлэл. Уб., 2021. 196 дахь тал

⁴ Нацагдорж, Ш., & Ишжамц, Н. (Ред.). Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх. Дэд боть. 1604-1917. Уб., 1968. 545 дахь тал.

⁵ Содовсүрэн, Б. Хувьсгалын өмнөх Монголын төр ба хууль цааз (1911-1920). Уб., 1989. 55 дахь тал.

⁶ Болдбаатар, Ж., Лүндээжанцан Д. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Нэмж засварласан гурав дахь хэвлэл. Уб., 2021. 196 дахь тал.

бусад асуудлын хүрээ буюу зохицуулсан харилцааны агуулга нь тухайн үеийн Монголын нийгмийн харилцааг бүхэлд нь хамарсан, гэхдээ иргэний ахуйн шинжтэй зарим харилцаа, монголын заншил, хэв ёсны тухайд бараг хөндөөгүй. Харин МУХЗБ нь 65 дэвтрээс бүрдэж буй бөгөөд 1000 орчим зүйл заалттай⁷. Эдгээр хоёр ХЗБ нь гадаад хэлбэрийн хувьд буюу хууль зүйн техникийн үүднээс харвал ерөнхийдөө ижил төстэй. Тийм ч учраас зарим судлаачид МУХЗБ Манжийн ХЗБ дээр ихээхэн хэмжээгээр суурилсан гэж үздэг. Зарим нь нэг хууль мэт андуурах⁸ нь ч бас бий. Иймд эхний удаад тус хоёр ХЗБ-ийг хэлбэрийн талаас нь ерөнхий агуулга (гарчиг)-ын хүрээнд дэвтэр тус бүрээр харьцуулж үзье.

Хүснэгт 1

ЗТГМТЗЯЯХЗБ	МУХЗБ
Уг айлтгал	-
Тэнхимийн түшмэдийн нэр зэрэг	-
Бүгдийн хууль (дээд)	2-р дэвтэр. Бүгдийн хууль Дундад
Бүгдийн хууль (доод)	3-р дэвтэр. Бүгдийн хууль Доод
1-р дэвтэр. Засаг хошуу	1-р дэвтэр. Бүгдийн хууль Дээд
2-р дэвтэр. Зэрэг дэв	-
3-р дэвтэр. Зэрэг залгамжлах нь (дээд)	4-р дэвтэр. Зэрэг залгамжлах нь Дээд
4-р дэвтэр. Зэрэг залгамжлах нь (доод)	5-р дэвтэр. Зэрэг залгамжлах нь Доод
5-р дэвтэр. Тушаал оролдсон нь	-
6-р дэвтэр. Түшмэл байгуулах нь	6-р дэвтэр. Түшмэл байгуулах тушаал хууль
7-р дэвтэр. Сонгож тавих нь	
8-р дэвтэр. Хөхиүлэх залхаах нь	
9-р дэвтэр. Эр төөлөх нь	11-р дэвтэр. Өрх амыг байцааж эр төөлөх хууль зүйл
10-р дэвтэр. Тариалан зах	-
11-р дэвтэр. Сангийн амуу	12-р дэвтэр. Сангийн амуу
12-р дэвтэр. Гааль авцгаах нь	13-р дэвтэр. Гааль татвар
13-р дэвтэр. Пүнлүүний мөнгө, пүнлүүний торго	14-р дэвтэр. Пүнлүүний мөнгө, пүнлүүний торго
14-р дэвтэр. Хүнс буулгах нь (дээд)	15-р дэвтэр. Хүнс буулгах нь
15-р дэвтэр. Хүнс буулгах нь (доод)	-

⁷ Одоогоор тус ХЗБ-ийн 63 дэвтэр нь монголоор, 2 дэвтэр нь япон хэлээр бий. Иймд япон орчуулгыг үндэслэж зүйл заалтыг тодорхой гаргах боломжгүй байгаа тул ийнхүү ойролцоогоор 1000 гаруй хэмээн тооцсон болно.

⁸ Рязановский, В.А. Монгольское право (преимущественно обычное). Исторический очерк. Харбин, Китай. 1931. Стр 81-113; Буянхишиг, Б. Хувийн эрх зүйн кодификац, онолын үндэс, тулгамдсан асуудал. Хууль зүйн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Уб., 2021. 11, 16 дахь тал. ... гэх мэт.

16-р дэвтэр. Бараалхан мөргөөр ирэх нь	-
17-р дэвтэр. Алба бариар ирэх нь	22-р дэвтэр. Алба бариар ирэх нь
18-р дэвтэр. Хуримлах шагнах нь (дээд)	26-р дэвтэр. Хуримлах шагнах ёслолын хууль
19-р дэвтэр. Хуримлах шагнах нь (доод)	-
20-р дэвтэр. Аялан явахад бараа болох хэргийн хууль (дээд)	24-р дэвтэр. Аялан явахад бараа болох хэргийн хууль
21-р дэвтэр. Аялан явахад бараа болох хэргийн хууль (дунд)	
22-р. Аялан явахад бараа болох хэргийн хууль (доод)	
23-р дэвтэр. Хууль дүрэм	-
24-р дэвтэр. Тамга тэмдэг	30-р дэвтэр. Тамга тэмдэг
25-р дэвтэр. Ураг бололцох ёслол	27-р дэвтэр. Ураг барих ёслолын хууль
26-р дэвтэр. Шагнан тайх нь	32-р дэвтэр. Тайх тахиглах ёслолын хууль
27-р дэвтэр. Илэрхийлэн тэмдэглэх нь	-
28-р дэвтэр. Өршөөн шагнах нь	28-р дэвтэр. Өршөөн шагнах хууль
29-р дэвтэр. Цэргийн засаг	37-р дэвтэр. Цэргийн хэргийн хууль Тэргүүн 38-р дэвтэр. Цэргийн хэргийн хууль Дундад 39-р дэвтэр. Цэргийн хэргийн хууль Доод
30-р дэвтэр. Чуулган чуулах нь	40-р дэвтэр. Чуулган чуулах нь
31-р дэвтэр. Өртөөний засаг (дээд)	41-р дэвтэр. Өртөөний засаг Дээд
32-р дэвтэр. Өртөөний засаг (дундад)	42-р дэвтэр. Өртөөний засаг Дундад
33-р дэвтэр. Өртөөний засаг (доод)	43-р дэвтэр. Өртөөний засаг Доод
34-р дэвтэр. Хязгаарт цаазлах нь	45-р дэвтэр. Нутгийн хэргийн хууль
35-р дэвтэр. Хүний амь	49-р дэвтэр. Хүний амь
36-р дэвтэр. Илт булаах нь	50-р дэвтэр. Илт булаах нь
37-р дэвтэр. Битүү хулгах нь (дээд)	51-р дэвтэр. Битүү хулгах нь Дээд
38-р дэвтэр. Битүү хулгах нь (доод)	52-р дэвтэр. Битүү хулгах нь Доод
39-р дэвтэр. Хүүр эрэх нь	53-р дэвтэр. Хүүр эрэх нь
40-р дэвтэр нь. Явалдах нь	54-р дэвтэр. Явалдах нь
41-р дэвтэр. Аргадан авч худалдах, аргадан авч худалдан авах нь	55-р дэвтэр. Аргадан авч худалдах, аргадан авч худалдан авах нь
42-р дэвтэр. Гэрчлэх заалдах нь	56-р дэвтэр. Гэрчлэх заалдах нь
43-р дэвтэр. Шүүн таслах нь	47-р дэвтэр. Ял шүүх нь Доод
44-р дэвтэр. Ялд авах нь	46-р дэвтэр. Эрүүгийн хуулийн дээд (Ял шүүх нь Дээд. Б.Б.)

45-р дэвтэр. Шахаанд оруулах нь	57-р дэвтэр. Шахаанд оруулах нь
46-р дэвтэр. Омтгойтон алдагдах нь	58-р дэвтэр. Омтгойтон алдагдах нь
47-р дэвтэр. Барих оргох нь	59-р дэвтэр. Барих ба оргох нь
48-р дэвтэр. Гянданд хориулах нь	60-р дэвтэр. Гянданд хориулах нь
49-р дэвтэр. Дагалдуулан хүргүүлэх нь	
50-р дэвтэр. Агуулж тэжээлгэх нь	61-р дэвтэр. Агуулж тэжээлгэх нь
51-р дэвтэр. Золио авах нь	-
52-р дэвтэр. Хэлтрүүлэх зарлигт учралдах нь	62-р дэвтэр. Хэлтрүүлэх зарлигт учралдах нь
53-р дэвтэр. Цаазалсныг зөрөх нь	64-р дэвтэр. Цаазалсныг зөрчих нь
54-р дэвтэр. Хугацаа хугацах нь	63-р дэвтэр. Хугацаа хугацах нь
55-р дэвтэр. Бага сага ял	65-р дэвтэр. Янз бүрийн гэмт хэрэг / япон хэлээрх эх/
56-р дэвтэр. Лам нарын хэргийн хууль (тэргүүн)	34-р дэвтэр. Лам нарын хэргийн хууль Дээд 35-р дэвтэр. Лам нарын хэргийн хууль Дундад 36-р дэвтэр. Лам нарын хэргийн хууль Доод
57-р дэвтэр. Лам нарын хэргийн хууль (хоёрдугаар)	
58-р дэвтэр. Лам нарын хэргийн хууль (гуравдугаар)	
59-р дэвтэр. Лам нарын хэргийн хууль (дөрөвдүгээр)	
60-р дэвтэр. Лам нарын хэргийн хууль (тавдугаар)	
61-р дэвтэр. Баруун зуугийн бүгд хууль (дээд)	-
62-р дэвтэр. Баруун зуугийн бүгд хууль (доод)	-
63-р дэвтэр. Оросын хэргийн хууль	-

Дурдсан харьцуулалтаас харвал МУХЗБ-ийн ихэнх дэвтрийг буюу судлаачдын бичсэнчлэн үнэхээр ...51 дэвтэр нь бүхэлдээ Манжийн хуучин хуулийн заалтыг ... найруулан зассан шинжтэй⁹ мэт харагдаж байна. Мөн харьцуулалтаас Манжийн ХЗБ-ийн Уг айлтгал, түүнд буй Тэнхимийн түшмэдийн нэр зэрэг, түүнчлэн 63 дэвтрийн 2, 5, 10, 15, 16, 19, 23, 27, 51, 61, 62, 63-р дэвтэр буюу нийт 12 дэвтрийн агуулга МУХЗБ-т тусаагүй. Харин бусад дэвтрүүд нь МУХЗБ-ийн 1-6, 11-15, 22, 24, 26-28, 30, 32, 34-43, 45-47, 49-65 дугаар дэвтрүүдийн агуулгатай ямар нэгэн байдлаар, ялангуяа хуулийн нэрийн хувьд ихээхэн адил төстэй байна. Магадгүй судлаачид эдгээр хуулийн нэрийн агуулга болон бусад цөөн дэвтрийг төлөөлүүлэн сонгон авч харьцуулалт хийж, дээр дурдсанчлан 50 гаруй дэвтэр нь өөрчлөн

⁹ Болдбаатар, Ж., Лүндээжанцан Д. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Нэмж засварласан гурав дахь хэвлэл. Уб., 2021. 196 дахь тал.

найруулсан шинжтэй хэмээн дүгнэсэн байж болох талтай. Түүнчлэн МУХЗБ-ийн Зочдыг зочлох нь, Хүү сангийн цааз хууль, Цагийг уламжлах нь, Тайх тахиглах ёслолын хууль, Ёслолын цаазын бичиг зэрэг 6 дэвтрийг шинээр зохион боловсруулсан¹⁰ тухай мэдээлсэн нь бий. Дээр авч үзсэн ерөнхий харьцуулалтаас үзвэл МУХЗБ-ийн 17 дэвтэр (7-10, 16-21, 23, 25, 29, 31, 33, 44, 48)-ийг шинээр боловсруулсан гэж үзэхээр байна. Гэхдээ үүнийг нарийвчилсан харьцуулалтын үр дүнд үндэслэн тогтоох нь зүйтэй.

V. Манж, Монгол Хууль зүйлийн бичгийн агуулгын харьцуулалт

Ийнхүү хуулийн нэр буюу гарчгаар нь харьцуулалт хийж дээрх үнэлэлт дүгнэлтийг хийсэн нь нэг талаар тус дүгнэлт бодитой эсэхэд эргэлзээ төрүүлж байна. Нөгөө талаар энэ нь нарийвчилсан байдлаар харьцуулж, үнэлэлт дүгнэлт өгөх шаардлагатайг харуулж байна. Иймд агуулгын нарийвчилсан харьцуулалтыг зүйл заалт тус бүрээр нь хийсэн бөгөөд харьцуулсан судалгаанаас 1) шинээр хуульчилсан, 2) өөрчлөн найруулсан мэт харагдаж байгаа боловч угтаа өөрчлөн найруулсан биш, харин шинээр хуульчилсан гэж үзэж болохуйц дэвтэр цөөнгүй байна. 3) Ихэнх зүйлийг ихээхэн хэмжээгээр өөрчилсөн, 4) үг, үсгийн зэргийг хөндсөн бага сага өөрчлөлт, 5) тухайн зүйлийг огт өөрчлөлгүй хэвээр авч ашигласан зэрэг ялгаа бүхий байдал ажиглагдаж буй. Эдгээрийн эхний хоёрыг нэгтгэн “шинээр хэм хэмжээ тогтоосон”, сүүлийн гурвыг нэгтгэн “өөрчлөн найруулсан” гэсэн үндсэн 2 хэсэгт хувааж болмоор байна.

Одоогийнхоор авч үзвэл эхний тохиолдолд “шинэчилсэн найруулга”-тай, хоёр дахь тохиолдолд “1. нэмэлт, өөрчлөлт оруулах, 2. нэмэлт оруулах, 3. өөрчлөлт оруулах, 4. хүчингүй болсонд тооцох” төрлүүдтэй төстэй юм. Гэхдээ орчин үеийн хуулийн төслийн төрлийг тодорхойлж буй шалгуураар үнэлж буй хэрэг биш гэдгийг цохон тэмдэглэе. Мэдээж хэрэг өнөөгийн хуулийн төсөлд тавигдах шаардлага, шалгуурыг тэр үеийн хуульд тавих нь зохисгүй, тэгээд ч тухайн үед хууль зүйн ийм техникийн шинжүүдийг нарийн харгалздаггүй байсан тул агуулгын хийгээд ижил төстэй шинжийг нь үндэслэн дээрх 2 төрөлд багцлан авч үзэх нь зүйтэй гэж үзэв. Ингэхдээ тухайн үед МУХЗБ-ийг боловсруулж системчлэхдээ “нэмэх”, “өөрчлөн найруулах”, “хасах” зэрэг өөрчлөлтийг хийсэн байдал түгээмэл байгааг мөн харгалзсан болно.

Иймд 1) шинээр тогтоосон хууль (дэвтэр) гэдэгт тухайн хуулийг шинээр тогтоосныг болон тухайн хуулийн нийт заалтын ихэнх

¹⁰ Мөн тэнд.

(ойролцоогоор 80-аас дээш хувь) хувьд нь нэмэлт, өөрчлөлт орсон, эсхүл тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв, агуулгад ихээхэн өөрчлөлт орсныг хамааруулав. Харин 2) өөрчлөн найруулсан гэдэгт Манжийн ХЗБ-ээс тодорхой зүйл заалтыг өөрчилсөн, нэмсэн, хассан, өөрчлөн найруулсан зэргийг хамтатган тооцлоо. Зүйл заалт тус бүрээр нь нарийвчлан харьцуулахдаа агуулгын болон техникийн үзүүлэлтийг шалгуур болгосныг дурдах нь зүйтэй бөгөөд агуулгын өөрчлөлтийн тухайд тухай бүр тодорхой дэвтрүүдэд жишээ болгон дурдаж, харин эх бичвэрийн харьцуулсан судалгааг бүхэлд нь энэ өгүүлэлд багтаан оруулах боломжгүй¹¹ тул дор хүснэгтэд хураангуйлж нэгтгэн харуулав.

Хүснэгт 2

МУХЗБ-г шинээр хуульчилсан дэвтэр

Манжийн ХЗБ	МУХЗБ	Тайлбар
<i>Дэвтрийн дугаар, хуулийн нэр, зүйлийн тоо</i>	<i>Дэвтрийн дугаар, хуулийн нэр, зүйлийн тоо</i>	
МУХЗБ-г Манжийн ХЗБ-ийн техникийг ашиглаж шинээр тогтоосон хууль		
1-р дэвтэр. Засаг хошуу. 16 зүйл	1-р дэвтэр. Бүгдийн хууль Дээд. 7 зүйл	Манжийн ХЗБ-ийн дэвтрүүдэд буй хэм хэмжээнээс нэг ч зүйл заалт ороогүй. Зохицуулсан харилцааны агуулга өөр.
Бүгдийн хууль (дээд). 17 зүйл	2-р дэвтэр. Бүгдийн хууль Дундад. 9 зүйл	
Бүгдийн хууль (доод). 28 зүйл	3-р дэвтэр. Бүгдийн хууль Доод. 5 зүйл	
11-р дэвтэр. Сангийн амуу. 8 зүйл	12-р дэвтэр. Сангийн амуу. 13 зүйл	Хуулийн хэм хэмжээний агуулга нь огт өөр, ижил төсөөтэй зохицуулалт байхгүй. Гагцхүү МУХЗБ-ийн тус хуульд буй 1 л зүйл Манжийн ХЗБ-ийн 10 дугаар дэвтэр (Тариалан зах)-ийн 1 зүйл (318-р зүйл)-тэй ерөнхий агуулгын хувьд төстэй.

¹¹ Манжийн ХЗБ болон МУХЗБ-ийн дэвтэр бүрд буй хуулийн зүйл заалтын харьцуулалтыг нэгбүрчлэн оруулах боломжгүй (хуудасны тоо их) тул тухайн дэвтрийн дугаар, хуулийн нэр, зүйлийн тоог дурдаж, тайлбар хэсэгт шинээр тогтоосон болон өөрчлөн найруулсан гэж үзэж буй үндэслэлийг бичсэн болно. Нарийвчилсан харьцуулалтын хуудасны тоо 1000 орчим болов.

		Гэхдээ тухайн зүйлийг ихээхэн өөрчлөн найруулсан.
12-р дэвтэр. Гааль авцгаах нь. 29 зүйл	13-р дэвтэр. Гааль татвар. 20 зүйл	2 зүйл агуулгын хувьд давхцаж буй. Манжийн ХЗБ-г буй 1 зүйлийг МУХЗБ-г 2 зүйл болгон системчилж, харин агуулгын хувьд өөрчлөн найруулсан. 1 зүйлийг нь багахан өөрчилсөн бөгөөд бусад ихэнх зүйл заалтыг шинээр тогтоосон. Тус дэвтэрт буй 20 зүйлийн 17-г нь шинээр хуульчилсан.
17-р дэвтэр. Алба бариар ирэх нь.	22-р дэвтэр. Алба бариар ирэх нь.	Агуулга нь өөр. Шинээр 3 зүйлийг нэмж, Манжийн ХЗБ-ээс 18 зүйлийг хасаж, 1 зүйлийг нь агуулгын хувьд ихээхэн өөрчилсөн.
18-р дэвтэр. Хуримлах шагнах нь (Дээд). 31 зүйл 19-р дэвтэр. Хуримлах шагнах нь (Доод). 20 зүйл	26-р дэвтэр. Хуримлах шагнах ёслолын хууль. 13 зүйл	Ижил төстэй зүйл заалт байхгүй. Нийт 13 зүйлтэй бөгөөд 1 зүйл нь Манжийн ХЗБ-ийн 596-р зүйл болох “Есөн цагааны алба бариар ирсэн элч нарт хуримлах шагнах нь” гэх зүйлийн нэртэй төстэй байгаа (МУХЗБ-ийн дурдсан зүйлийн нэр “Есөн цагаан бариар ирэхэд хуримлах шагнах нь” гэж буй) хэдий ч агуулга нь өөр юм.
20-р дэвтэр. Аялан явахад бараа болох хэргийн хууль (дээд). 21-р дэвтэр. Аялан явахад бараа болох хэргийн хууль (дундад). 22-р дэвтэр. Аялан явахад бараа болох хэргийн хууль (доод)	24-р дэвтэр. Аялан явахад бараа болох хэргийн хууль. 8 зүйл	Агуулгын хувьд огт өөр. Манжийн ХЗБ-ийн тус 3 дэвтрийн нийт 142 зүйлтэй аль ч хэм хэмжээ нь ижил төстэй гэх агуулга байхгүй.
24-р дэвтэр. Тамга тэмдэг. 11 зүйл	30-р дэвтэр. Тамга тэмдэг. 25 зүйл	Хуулийн нэр адил боловч зохицуулсан хэм хэмжээний агуулга огт өөр.
26-р дэвтэр. Шагнан тайх нь. 15 зүйл	32-р дэвтэр. Тайх тахиглах ёслолын хууль.	1 зүйлийн агуулга төстэй. Гэхдээ тухайн зүйлийн агуулга Манжийн хууль цаазаас авсан гэхээс илүүтэй Манж нар Монголын хууль цааз, зан заншлыг хүлээн зөвшөөрч

		өөрсдийн хуульдаа баталгаажуулсан. 4 зүйлийг шинээр хуульчилсан.
29-р дэвтэр. Цэргийн засаг. 20 зүйл	38-р дэвтэр. Цэргийн хэргийн хууль Дундад. 20 зүйл	Манжийн ХЗБ-ээс 1 зүйлийг өөрчлөн найруулж 38-р дэвтэрт, 2 зүйлийг их хэмжээгээр өөрчилж 39 дүгээр дэвтэрт тус тус системчилсэн.
	39-р дэвтэр Цэргийн хэргийн хууль Доод. 9 зүйл	
31-р дэвтэр. Өртөөний засаг (Дээд). 81 зүйл	41-р дэвтэр. Өртөөний засаг Дээд. 13 зүйл	МУХЗБ-ийн 41-р дэвтрийг шинээр хуульчилсан.
32-р дэвтэр. Өртөөний засаг (Дундад). 44 зүйл	42-р дэвтэр. Өртөөний засаг Дундад. 17 зүйл	МУХЗБ-ийн 42-р дэвтрийг шинээр хуульчилсан.
42-р дэвтэр. Гэрчлэх заалдах нь. 7 зүйл	56-р дэвтэр. Гэрчлэх заалдах нь. 16 зүйл	Манжийн ХЗБ-ийн 42-р дэвтрээс 4 зүйлийг өөрчлөн найруулж, 1 зүйлийг өөрчлөлгүй хэвээр авч, 1 зүйлийг хасаж, 11 зүйлийг шинээр нэмсэн (Эдгээр 11 зүйлд буй 1 зүйлийг ихээхэн өөрчилсөн). Дийлэнх зохицуулалтыг шинээр хуульчилсан.
50-р дэвтэр. Агуулж тэжээлгэх нь. 2 зүйл	61-р дэвтэр. Агуулж тэжээлгэх нь. 20 зүйл	2 зүйлийг өөрчлөн найруулж, шинээр 18 зүйл нэмсэн.

Бүгд 16 дэвтэр

**МУХЗБ-т шинээр тогтоосон хуулиуд
(Манжийн ХЗБ-гэй хамааралгүй)**

7-р дэвтэр. Түшмэлийн засаг Тэргүүн. 6 зүйл; 8-р дэвтэр. Түшмэлийн засаг Хоёрдугаар. 11 зүйл; 9-р дэвтэр. Түшмэлийн засаг Гуравдугаар. 32 зүйл; 10-р дэвтэр. Түшмэлийн засаг Дөрөвдүгээр. 19 зүйл; 16-р дэвтэр. Хүү сангийн цааз хууль. 28 зүйл; 17-р дэвтэр. Ёслолын хууль дүрэм Тэргүүн. 11 зүйл; 18-р зүйл. Ёслолын хууль дүрэм Хоёрдугаар. 27 зүйл; 19-р дэвтэр. Ёслолын хууль дүрэм Гуравдугаар. 20 зүйл; 20-р дэвтэр. Ёслолын хууль дүрэм Дөрөвдүгээр. 10 зүйл; 21-р дэвтэр. Ёслолын хууль дүрэм Тавдугаар. 12 зүйл; 23-р дэвтэр. Зочдыг зочлох нь. 5 зүйл; 25-р дэвтэр. Олон жагсаалын хууль. 4 зүйл; 29-р дэвтэр. Цагийг уламжлах нь. 8 зүйл; 31-р дэвтэр.

Өргөмжлөл, жуух олгуулах нь. 5 зүйл; 33-р дэвтэр. Ёслолын цаазын бичиг. 15 зүйл; 34-р дэвтэр. Лам нарын хэргийн хууль Дээд. 63 зүйл; 44-р дэвтэр. Сүүргийн засаг. 5 зүйл; 46-р дэвтэр. Эрүүгийн хуулийн дээд (*Ял шүүх нь Дээд. Б.Б.*).

Бүгд 18 дэвтэр

Манжийн ХЗБ-ийн Бүгдийн хууль (дээд), Бүгдийн хууль (доод) болон 1-р дэвтэрт Өвөрмонгол, Халхын нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, төрийн байгууллагын бүтэц, орон тоог тогтоосон. Харин МУХЗБ-ийн 1-3-р дэвтэрт тусгаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн байгууллын асуудлыг хуульчлан зохицуулсан бөгөөд 5 яамны бүтэц, орон тоо, эрхлэн шийтгэх чиг үүргийг заан тодорхойлжээ. Гагцхүү Манжийн ХЗБ-ийн Бүгдийн хууль (доод)-ийн 18 дугаар зүйлийн “Олон хэлтсийн эрхэлж шийтгэх тушаал” гэх нэр МУХЗБ-ийн 3-р дэвтрийн “Олон яам хэлтсийн эрхлэн шийтгэх хууль” гэх нэртэй ижил төстэй байна. Манжийн ХЗБ-ийн дурдсан дэвтэрт буй 61 зүйлээс МУХЗБ-т огт авч ашиглаагүй, зохицуулсан хэм хэмжээнүүд агуулгын хувьд ч огт өөр юм. Иймд МУХЗБ-ийн дурдсан дэвтрүүдийг шинээр хуульчилсан байна.

Манжийн ХЗБ-ийн 11-р дэвтэр болох “Сангийн амуу” гэх хууль нь МУХЗБ-ийн 12-р дэвтэр болох “Сангийн амуу”-ны хуультай ижил гарчигтай. Энэ үүднээс судлаачид МУХЗБ-т ...Манжийн үеийн хуульд байсан зарим зүйл заалтыг улс төр, нийгэм эдийн засгийн ач холбогдлоор нь хураангуйлах буюу дэлгэрүүлэн оруулах зарчим баримталжээ, тухайлбал, Сангийн амууны тухай манж ХЗБ-т 3 удаа тэмдэглэсэн байсныг МУХЗБ-т 11 зүйл болгон дэлгэрүүлэн оруулсан юм¹² гэжээ. Гэтэл харьцуулсан судалгааны үр дүн энэ дүгнэлтийн эсрэг гарч байна. Хэдийгээр хоёр хуулийн нэр адил байгаа боловч тухайн хуулийн хэм хэмжээний агуулга нь огт өөр байна. Гагцхүү МУХЗБ-ийн тус дэвтэрт буй 1 л зүйл Манжийн ХЗБ-ийн 10 дугаар дэвтэр (Тариалан зах)-ийн 1 зүйл (318-р зүйл)-тэй ерөнхий агуулгын хувьд төстэй ажээ. Гэвч тухайн зүйлийг ихээхэн өөрчлөн найруулсан. Бусад бүх зүйлд (Манжийн ХЗБ-ийн тус дэвтэр нь 8, МУХЗБ-ийнх 13 зүйлтэй) ижил төсөөтэй зохицуулалт, агуулга огт үгүй тул энэхүү хуулийг шинээр боловсруулан хуульчилсан гэж үзэж болно. Үүнтэй адил Манжийн ХЗБ-ийн 12-р дэвтэр (“Гааль авцгаах нь” гэх нэртэй, 29 зүйлтэй), МУХЗБ-ийн 13-р дэвтэр (“Гааль татвар” гэх нэртэй, 20 зүйлтэй)-ийн 2 зүйл агуулгын хувьд давхцаж буй. Гэхдээ системчлэлийн хувьд дээрхээс өөр буюу Манжийн ХЗБ-т буй 1 зүйлийг МУХЗБ-т 2 зүйл болгон системчилж, харин агуулгын хувьд өөрчлөн найруулжээ. 1 зүйлийг нь багахан өөрчилсөн бөгөөд

¹² Болдбаатар, Ж., Лүндээжанцан Д. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Нэмж засварласан гурав дахь хэвлэл. Уб., 2021. 196 дахь тал.

бусад ихэнх зүйл заалтыг шинээр тогтоосон байна. Тус дэвтэрт буй 20 зүйлийн 17-г нь шинээр хуульчилсан тул энэ дэвтрийг шинэ хэм хэмжээ бүхий хууль гэж үзэх боломжтой. Энэ мэтчилэн харьцуулсан судалгааны үр дүнгээс харвал МУХЗБ-ийн 16 дэвтрийг Манжийн ХЗБ-ийн техникт үндэслэн шинээр тогтоосон байх бөгөөд 7-10, 16-21, 23, 25, 29, 31, 33, 34, 44, 46-р дэвтэр болох 18 дэвтрийг цоо шинээр тогтоосон буюу нийт 34 дэвтрийг шинээр боловсруулан хуульчилжээ.

Харин өөрчлөн найруулсан хуулиудын хувьд хэд хэдэн онцлог бий. Тухайлбал, Манжийн ХЗБ-ийн “Зэрэг залгамжлах нь (дээд)” гэх 3-р дэвтэр, МУХЗБ-ийн 4-р дэвтэр (Зэрэг залгамжлах нь Дээд)-тэй агуулга ихээхэн төстэй. Тус дэвтрийн 40 зүйлээс 25 зүйлийн агуулга нь МУХЗБ-т буй агуулгатай ижил байна. Албан тушаалын болон төрийн байгууллагын нэршил зэргийн ялгаа бий бөгөөд МУХЗБ-т шинээр 3 зүйлийг нэмж өөрчлөн найруулсан. Эндээс тухайн хуульд бага хэмжээний өөрчлөлт оруулжээ гэж үзэж болно. Мөн Манжийн ХЗБ-ийн 4-р дэвтэр (Зэрэг залгамжлах нь (доод)), МУХЗБ-ийн 5-р дэвтэр (Зэрэг залгамжлах нь Доод)-ийн гарчиг ижил боловч 36 зүйлээс 5 зүйлийн агуулгыг МУХЗБ-т бага сага өөрчлөн найруулж системчилжээ. Ингэхдээ Манжийн ХЗБ-ийн 31 зүйлийг хүчингүй болгон хасаж, шинээр 11 зүйлийг нэмсэн. Өөрөөр хэлбэл, МУХЗБ-ийн тус дэвтрийг ихээхэн хэмжээгээр өөрчлөн найруулсан байна.

Түүнчлэн Манжийн ХЗБ-ийн 6, 7, 8-р дэвтрийг МУХЗБ-т өөрчлөн найруулж 1 дэвтэрт нэгтгэн хураангуйлж системчилсэн. Манжийн ХЗБ-ийн эдгээр дэвтэр нийт 69 зүйлтэй, түүнээс 45 зүйлийг нь хасаж хүчингүй болгожээ. МУХЗБ-т шинээр 11 зүйлийг нэмсэн. Үлдсэн 24 зүйлийн агуулга нь МУХЗБ-ийн агуулгатай төстэй. Үүнээс бага сага өөрчилсөн 11, ихээхэн өөрчлөн найруулсан 7, огт өөрчлөлт оруулаагүй 5 зүйл байна. Мөн Манжийн ХЗБ-ийн 2 зүйлийг МУХЗБ-т нэгтгэн 1 зүйл болгон хураангуйлж өөрчлөн найруулсан нь ч бас бий. Иймд Манжийн ХЗБ-ийн дурдсан 3 дэвтрийг МУХЗБ-т 1 дэвтэр болгон ихээхэн өөрчлөн найруулжээ.

Манжийн “ХЗБ-ийн Хүнс буулгах нь (дээд)” гэх 14-р дэвтрийн зарим хэм хэмжээ МУХЗБ-ийн 15-р дэвтэр (Хүнс буулгах нь)-ийн зарим хэм хэмжээтэй агуулгын хувьд давхцаж буй. 46 зүйлээс 39 зүйлийг шууд хасаж, шинээр 15 зүйлийг нэмжээ. Харьцуулагдаж буй 7 зүйлийг ажиглавал Манжийн ХЗБ-ийн зүйлүүдэд заасан хэм хэмжээ дэлгэрэнгүй байсныг нэлээд хураангуйлж, ихээхэн хэмжээгээр өөрчлөн найруулсан байна. Агуулгын хувьд Манжийн ХЗБ-ийн 15-р дэвтэр болох “Хүнс буулгах нь (доод)” гэх дэвтэр МУХЗБ-ийн тус дэвтэрт хамаарахаар байна. Гэвч ижил төстэй зохицуулалт үгүй байгаа нь МУХЗБ-ийг системчлэхдээ тухайн дэвтрийг бүхэлд нь

хүчингүй болгож хассан буюу огт ашиглаагүй гэдгийг харуулж буй.

Цэргийн засаг нэртэй 20 зүйл бүхий Манжийн ХЗБ-ийн 29-р дэвтрийг МУХЗБ-т 3 дэвтэр (37-р дэвтэр Цэргийн хэргийн хууль Тэргүүн, 38-р дэвтэр Цэргийн хэргийн хууль Дундад, 39-р дэвтэр Цэргийн хэргийн хууль Доод) болгон дэлгэрүүлсэн гэж үздэг. Нарийвчилсан харьцуулалтаас харвал дэлгэрүүлсэн гэхээс илүүтэй ихэнх хэм хэмжээг шинээр тогтоосон байна. Манжийн ХЗБ-ээс 9 зүйлийг хассан. Үлдсэн 9 зүйлийн 3 зүйлийг их, 3 зүйлийг бага хэмжээгээр өөрчлөн найруулж 37-р дэвтэрт, 1 зүйлийг өөрчлөн найруулж 38-р дэвтэрт, 2 зүйлийг их хэмжээгээр өөрчилж 39 дүгээр дэвтэрт тус тус оруулжээ. Гэтэл МУХЗБ-ийн 37-р дэвтэр 26, 38-р дэвтэр 20, 39-р дэвтэр 9, нийт 55 зүйлтэй. Өөрөөр хэлбэл, МУХЗБ-ийн тус 3 дэвтэрт 45 зүйлийг шинээр хуульчилсан байна. Шинэ хэм хэмжээний хувь ихэнх хэсгийг эзэлж байгаа тул, ялангуяа 38, 39-р дэвтрийг шинээр нэмсэн гэж үзэж болно. Тухайн дэвтэрт буй зүйл заалтын хүрээнд авч үзвэл 37-р дэвтрийг өөрчлөн найруулсан гэж үзэх боломжтой. Нөгөө талаар 1912 оноос үндэсний цэргийн анги хороодыг байгуулж, холбогдох хууль дүрмийг, тухайлбал 23 зүйл бүхий Монгол цэргийн дагаж явах түр дүрэм хэмжээг боловсруулж Богд хаанд айлтган батлуулсан байдаг. Энэ дүрэм Монгол Улсын цэргийн зохион байгуулалтын үндсэн зарчим, эрх зүйн үндсийг тодорхойлсон бөгөөд түүнд буй хэм хэмжээг МУХЗБ-т зохих хэмжээгээр оруулж системчилсэн юм¹³. Товчоор хэлбэл МУХЗБ-ийн дурдсан 3 хуулийг боловсруулахдаа Манжийн ХЗБ-ийн 1 хуулиас зарим зүйл заалтыг, мөн тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан цэргийн дүрэм журмаас зохих хэм хэмжээнүүдийг өөрчлөн найруулж, заримыг хэвээр улируулан авч системчилсэн бөгөөд үндсэндээ 3 дэвтрийн 1-ийг өөрчлөн найруулж, 2-ыг нь шинээр нэмсэн. Энэ мэтчилэн олон өөрчлөлт, онцлогийг дурдаж болох бөгөөд энд бүгдийг хамруулах боломжгүй тул доор өөрчлөн найруулж шинэчилсэн хуулиудыг хүснэгтэд хураангуйлж нэгтгэн харуулав.

Хүснэгт 3

МУХЗБ-т Манжийн ХЗБ-ээс өөрчлөн найруулж оруулсан хууль

Манжийн ХЗБ	МУХЗБ	Тайлбар
3-р дэвтэр. Зэрэг залгамжлах нь (дээд). 40 зүйл	4-р дэвтэр. Зэрэг залгамжлах нь (Дээд)	Агуулга ихээхэн төстэй. Тус дэвтрийн 40 зүйлээс 25 зүйлийн агуулга нь МУХЗБ-т буй агуулгатай ижил байна. Албан тушаалын болон төрийн байгууллагын нэршил зэргийн ялгаа буй

¹³ Болдбаатар, Ж., Лүндээнжанцан Д. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Нэмж засварласан гурав дахь хэвлэл. Уб., 2021. 186 дахь тал.

		бөгөөд МУХЗБ-т шинээр 3 зүйлийг нэмж өөрчлөн найруулсан.
4-р дэвтэр. Зэрэг залгамжлах нь (доод). 36 зүйл	5-р дэвтэр. Зэрэг залгамжлах нь Доод.	36 зүйлээс 5 зүйлийн агуулгыг МУХЗБ-т бага сага өөрчлөн найруулж системчилжээ. Ингэхдээ Манжийн ХЗБ-ийн 31 зүйлийг хасаж, шинээр 11 зүйлийг нэмсэн. Өөрөөр хэлбэл, МУХЗБ-ийн тус дэвтрийг ихээхэн хэмжээгээр өөрчлөн найруулсан.
6-р дэвтэр. Түшмэл байгуулах нь. 40 зүйл 7-р дэвтэр. Сонгож тавих нь. 20 зүйл 8-р дэвтэр. Хөхиүлэх, залхаах нь. 6 зүйл	6-р дэвтэр. Түшмэл байгуулах тушаал хууль. 34 зүйл	Манжийн ХЗБ-ийн 6, 7, 8-р дэвтрийг МУХЗБ-т өөрчлөн найруулж 1 дэвтэрт нэгтгэн хураангуйлж системчилсэн. Манжийн ХЗБ-ийн эдгээр дэвтэр нийт 69 зүйлгэй, түүнээс 45 зүйлийг нь хасаж, МУХЗБ-т шинээр 11 зүйлийг нэмсэн. Үлдсэн 24 зүйлийн агуулга нь МУХЗБ-ийн агуулгатай төстэй. Үүнээс бага сага өөрчилсөн 11, ихээхэн өөрчлөн найруулсан 7, огт өөрчлөлт оруулаагүй 5 зүйл байна. Мөн Манжийн ХЗБ-ийн 2 зүйлийг МУХЗБ-т нэгтгэн 1 зүйл болгон хураангуйлж өөрчлөн найруулсан нь ч бас бий. Иймд Манжийн ХЗБ-ийн дурдсан 3 дэвтрийг МУХЗБ-т 1 дэвтэр болгон ихээхэн өөрчлөн найруулжээ.
9-р дэвтэр. Эр төөлөх нь. 22 зүйл	11-р дэвтэр. Өрх амыг байцааж эр төөлөх хууль зүйл. 30 зүйл	МУХЗБ-т 19 зүйлийг шинээр нэмж, Манжийн ХЗБ-ээс 13 зүйлийг хассан. Мөн дээрхтэй адил 2 зүйлийг 1 зүйлд нэгтгэн, агуулгыг ихээхэн өөрчилсөн. Бага өөрчлөлт бүхий 5, их өөрчилсөн 3, огт өөрчлөөгүй 1 зүйл байгаа нь тус дэвтрийг ихээхэн өөрчлөн найруулж системчилжээ гэж үзэхэд хүргэж буй.
13-р дэвтэр. Пүнлүүний мөнгө, пүнлүүний торго. 49 зүйл	14-р дэвтэр. Пүнлүүний мөнгө, пүнлүүний торго. 22 зүйл	МУХЗБ-т 5 зүйлийг шинээр хуульчилсан. 17 зүйл нь Манжийн ХЗБ-ийн холбогдох зүйлүүдтэй агуулгын хувьд төстэй боловч цөмийг өөрчлөн найруулсан байна.
14-р дэвтэр. Хүнс буулгах нь (дээд). 46 зүйл	15-р дэвтэр. Хүнс буулгах нь. 22 зүйл	Манжийн ХЗБ-ийн Хүнс буулгах нь (дээд) гэх 14-р дэвтрийн зарим хэм хэмжээ МУХЗБ-ийн 15-р дэвтэр (Хүнс буулгах нь)-ийн зарим хэм хэмжээтэй агуулгын хувьд давхцаж буй. 46 зүйлээс 39 зүйлийг шууд хасаж, шинээр 15 зүйлийг нэмжээ. Харьцуулагдаж буй

		7 зүйлийг ажиглавал Манжийн ХЗБ-ийн зүйлүүдэд заасан хэм хэмжээ дэлгэрэнгүй байсныг нэлээд хураангуйлж, ихээхэн хэмжээгээр өөрчлөн найруулсан. Агуулгын хувьд Манжийн ХЗБ-ийн 15-р дэвтэр болох Хүнс буулгах нь (доод) гэх дэвтэр МУХЗБ-ийн тус дэвтэрт хамаарахаар байна. Гэвч ижил төстэй зохицуулалт үгүй байгаа нь МУХЗБ-ийг системчлэхдээ тухайн дэвтрийг бүхэлд нь хассан буюу огт ашиглаагүй гэдгийг харуулж буй.
25-р дэвтэр. Ураг бололцох ёслолын хууль. 26 зүйл	27-р дэвтэр. Ураг барих ёслолын хууль. 18 зүйл	26 зүйлээс 17 зүйлийг хассан. МУХЗБ-т 10 зүйлийг шинээр нэмсэн. 7 зүйлийн агуулгыг харьцуулбал дараах ялгаа ажиглагдаж байна. 1) 1 зүйлийн нэр адилгүй боловч хэм хэмжээний агуулга төстэй байна. Гэхдээ агуулгыг ихээхэн өөрчлөн найруулсан. 2) багахан өөрчлөн найруулсан 5 зүйл, 3) 1 зүйлийн нэр гарчиг өөр боловч түүнийг МУХЗБ-т 2 зүйл болгон хуваасан. Эндээс тус дэвтрийн агуулгыг өөрчлөн найруулсан гэж үзэж болохоор байна.
28-р дэвтэр. Өршөөн шагнах нь. 9 зүйл	28-р дэвтэр. Өршөөн шагнах хууль. 5 зүйл	4 зүйлийг хасаж, үлдсэн 5 зүйлийг багахан өөрчлөн найруулжээ.
29-р дэвтэр. Цэргийн засаг. 20 зүйл	37-р дэвтэр. Цэргийн хэргийн хууль Тэргүүн. 26 зүйл	Манжийн ХЗБ-ээс 10 зүйлийг хассан. Шинээр 21 зүйл нэмсэн. 6 зүйлийг их, бага хэмжээгээр өөрчлөн найруулсан.
30-р дэвтэр. Чуулган чуулах нь. 20 зүйл	40-р дэвтэр. Чуулган чуулах нь. 11 зүйл	Манжийн ХЗБ-ийн 30-р дэвтрээс 7 зүйлийг авч өөрчлөн найруулж, бусад зүйлийг хасаж, шинээр 4 зүйлийг нэмсэн.
33-р дэвтэр. Өртөөний засаг (Доод). 29 зүйл	43-р дэвтэр. Өртөөний засаг Доод. 23 зүйл	Манжийн ХЗБ-ийн 33-р дэвтрээс 6 зүйлийг МУХЗБ-ийн 43-р дэвтэрт хураангуйлан нэгтгэж, өөрчлөн найруулсан байна. Тухайлбал, Манжийн ХЗБ-ийн 1050, 1051-р зүйлийг МУХЗБ-т 1 зүйл, мөн 1053, 1054-р зүйлийг мөн 1 зүйлд нэгтгэж системчилсэн, түүнчлэн 1055-р зүйлийг огт өөрчлөлгүй хэвээр авч ашиглажээ. Бусад бүх хэм хэмжээг шинээр нэмсэн.

34-р дэвтэр Хязгаарт цаазлах нь. 33 зүйл	45-р дэвтэр Нутгийн хэргийн хууль. 9 зүйл	Манжийн ХЗБ-ээс 6 зүйлийг өөрчлөн найруулж, 27 зүйлийг хасаж, шинээр 3 зүйлийг нэмсэн.
43-р дэвтэр. Шүүх таслах нь. 19 зүйл	47-р дэвтэр. Ял шүүх нь Доод. 9 зүйл	Манжийн ХЗБ-ээс 6 зүйлийг өөрчлөн найруулжээ, 11 зүйлийг хасаж, шинээр 3 зүйлийг нэмсэн.
35-р дэвтэр. Хүний амь. 11 зүйл	49-р дэвтэр. Хүний амь. 54 зүйл	Манжийн ХЗБ-ийн 11 зүйлийг бүхэлд нь өөрчлөн найруулж, шинээр 42 зүйлийг нэмжээ. Мөн Манжийн ХЗБ-ийн 51-р дэвтэрт буй 1252, 1253-р зүйлийг 1 зүйлд нэгтгэн, өөрчлөн найруулж системчилсэн.
36-р дэвтэр. Илт булаах нь. 13 зүйл	50-р дэвтэр. Илт булаах нь. 11 зүйл	2 зүйлийг хасаж, бусад зүйлийг өөрчлөн найруулсан.
37-р дэвтэр. Битүү хулгах нь (Дээд). 34 зүйл	51-р дэвтэр. Битүү хулгах нь Дээд. 45 зүйл	Манжийн ХЗБ-ийн 37-р дэвтрээс 10 зүйлийг хасаж, шинээр 19 зүйлийг нэмж, 15 зүйлийг өөрчлөн найруулж (ингэхдээ Манжийн ХЗБ-ийн 2 зүйлийг МУХЗБ-т 1 зүйлд нэгтгэсэн болон Манжийн ХЗБ-ийн 1 зүйлийг МУХЗБ-т 2 зүйл болгож салгасан нь бас бий), 8 зүйлийг өөрчлөлгүйгээр хэвээр авсан.
38-р дэвтэр. Битүү хулгах нь (Доод). 18 зүйл	52-р дэвтэр. Битүү хулгах нь Доод. 15 зүйл	Манжийн ХЗБ-ийн 38-р дэвтрээс 2 зүйлийг хасаж, 12 зүйлийг өөрчлөн найруулж (мөн дээрхтэй адил нэгтгэсэн, салгасан), 4 зүйлийг хэвээр авч, 1 зүйлийг шинээр нэмсэн.
39-р дэвтэр. Хүүр эрэх нь. 2 зүйл	53-р дэвтэр. Хүүр эрэх нь. 2 зүйл.	Тус 2 зүйлийг өөрчлөн найруулсан.
40-р дэвтэр. Явалдах нь. 4 зүйл	54-р дэвтэр. Явалдах нь. 4 зүйл.	Тус 4 зүйлийг өөрчлөн найруулсан.
41-р дэвтэр. Аргадан авч худалдах, аргадан авч худалдан авах нь. 3 зүйл	55-р дэвтэр. Аргадан авч худалдах, аргадан авч худалдан авах нь. 2 зүйл	1 зүйлийг хасаж, 2 зүйлийг өөрчлөн найруулсан.
45-р дэвтэр. Шахаанд оруулах нь. 6 зүйл	57-р зүйл. Шахаанд оруулах нь. 6 зүйл	4 зүйлийг хэвээр авч, 2 зүйлд өөрчлөлт оруулсан.

46-р дэвтэр. Омтгойтон алдагдах нь. 12 зүйл.	58-р дэвтэр. Омтгойтон алдагдах нь. 17 зүйл	11 зүйлийг өөрчилж, 6 зүйлийг шинээр нэмсэн.
47-р дэвтэр. Барих ба оргох нь. 6 зүйл	59-р дэвтэр. Барих ба оргох нь. 5 зүйл	4 зүйлийг өөрчилж, 1 зүйлийг хэвээр авч, 1 зүйлийг хассан.
48-р дэвтэр. Гянданд хориулах нь. 2 зүйл 49-р дэвтэр. Дагалдуулан хүргүүлэх нь. 4 зүйл	60-р дэвтэр. Гянданд хориулах нь. 8 зүйл	48-р дэвтрээс 1 зүйлийг өөрчлөн найруулж, нөгөөг хассан. 49-р дэвтрээс 1 зүйлийг өөрчлөн найруулж, бусад 3-ыг хассан. Шинээр 6 зүйлийг ШЦБ-ээс авч өөрчлөн найруулсан. 48, 49-р дэвтрийг 1 дэвтэрт нэгтгэсэн.
52-р дэвтэр. Хэлтрүүлэх зарлигт учралдах нь. 2 зүйл	62-р дэвтэр. Хэлтрүүлэх зарлигт учрах нь. 7 зүйл	2 зүйлийг өөрчлөн найруулж, шинээр 5 зүйлийг нэмсэн. Нэмсэн 5 зүйлийн 2 нь Манжийн ХЗБ-ийн өөр нэг хувилбараас (тус хувилбар эхийг хараахан олж чадсангүй), 3 зүйл нь ШЦБ-ээс өөрчлөн найруулж оруулсан. Иймд шинээр хуульчилсан бус, өөрчлөлт оруулсан гэж үзэв.
53-р дэвтэр. Цаазалсныг зөрөх нь. 13 зүйл	64-р дэвтэр. Цаазалсныг зөрчих нь. 5 зүйл	11 зүйлийг хасаж, 2 зүйлийг өөрчлөн найруулж, шинээр 3 зүйл нэмсэн.
54-р дэвтэр. Хугацаа хугацах нь. 12 зүйл	63-р дэвтэр. Хугацаа хугацах нь.	10 зүйлийг хасаж, 2 зүйлийг өөрчлөн найруулсан.
55-р дэвтэр. Бага сага ял. 13 зүйл	65-р дэвтэр. Янз бүрийн гэмт хэрэг (Японоос орчуулсан эх). 24 зүйл	12 зүйлийг өөрчлөн найруулж, бусад зүйлийг нэмсэн.
56-р дэвтэр. Лам нарын хэргийн хууль (тэргүүн). 65 зүйл	35-р дэвтэр. Лам нарын хэргийн хууль Дундад. 9 зүйл	Манжийн ХЗБ-ийн 56-р дэвтрээс 3 зүйлийг авч ихээхэн өөрчлөн найруулж, шинээр 6 зүйл нэмсэн.
59-р дэвтэр. Лам нарын	36-р дэвтэр. Лам нарын	Манжийн ХЗБ-ийн 59-р дэвтрээс 7 зүйлийг авч өөрчлөн найруулж, шинээр 2 зүйлийг

хэргийн хууль (дөрөвдүгээр). 22 зүйл	хэргийн хууль Доод. 9 зүйл	нэмсэн.
30 дэвтэр		

Дээр дурдсанаас үзвэл Манжийн ХЗБ-ийн цөөнгүй дэвтрийн тодорхой зүйл заалтуудыг МУХЗБ-ийг төрөлжүүлэхдээ авч ашигласан бөгөөд ингэхдээ нэмэлт оруулах, шаардлагагүй хэм хэмжээг хасах, шинээр хэм хэмжээ тогтоох, их бага аль нэгэн хэмжээгээр өөрчлөн найруулах, 1 зүйлийг 2 ба хэд хэдэн зүйлд, 2 ба түүнээс дээш зүйлийг 1 зүйлд хураангуйлах, тухайн үед үйлчилж буй Монголын төрөөс тогтоосон хууль дүрэм зэргээс зохих зүйл заалтыг дээрх байдлаар авч ашиглан системчилжээ.

Харьцуулсан судалгааны үр дүнгээс харвал нийт 30 дэвтрийн агуулгыг Манжийн ХЗБ болон ШЦБ-ийн зарим хэм хэмжээ, агуулга, техникт тулгуурлан өөрчлөн найруулж боловсруулжээ. Харин МУХЗБ-ийн 48-р дэвтэр (Цагаан өмсөх олон зурагт хууль)-ийг чухам аль хуулиас авсан хийгээд тухайн хуулийг шинээр тогтоосон, эсхүл өөрчлөн найруулсан, хэвээр авч ашигласан гэдгийг баттай тогтоож чадсангүй. Ямартай ч Манжийн төрөөс тогтоосон олон хууль зүйлийн аль нэгээс авсан бололтой. Магадгүй Манжийн ХЗБ-т өмнө хуульчлагдсан байсныг хожим удаа дараагийн өөрчлөлт оруулахдаа хүчингүй болгосон байхыг ч үгүйсгэхгүй. Дашрамд дурдахад тухайн хуульд заасан зүйлийг Богд хааны зарлигаар 1912 онд хэрэгсэхгүй болгож, монголчуудын уламжлалт шашны ёсоор эмгэнэл гашуудал үйлдэх зарлиг гарсан байдаг тул энэ хууль (48-р дэвтэр)-ийн хэм хэмжээ Монголын нийгэмд үйлчлээгүй юм.

Германы эрдэмтэн, доктор Удо Б.Баркманн нэгэн өгүүлэлдээ 1815 оны хуулийн эмхэтгэл (*ГМТЗЯЯХЗБ-ийг хэлж байна. Б.Б.*) монголчуудад 1911 он хүртэл хүчин төгөлдөр байсан бөгөөд үүнийг Богд хаант улсын төр Жавзандамбатай холбогдсон зарим хэдхэн зүйлийг хасаад хүчин төгөлдөр эрх зүйн хэм хэмжээ хэмээн 1919 он хүртэл баримталж байсан. Энэ нь он удаан жилийн туршид харийн хууль цааз монголчуудын амьдралыг зохицуулж байжээ гэсэн үг юм¹⁴ хэмээн дүгнэсэн байдаг. Сая авч үзсэн харьцуулсан судалгаанаас харвал Герман эрдэмтний дээрх дүгнэлт үндэсгүй байгааг шууд харж болохоор байна. Харин Японы эрдэмтэн Шимада Масао тус хоёр хуулийн зарим дэвтрийг харьцуулан судлаад МУХЗБ-ийг

¹⁴ Удо Б.Баркманн. Гадаад мужийг засах яам (манжаар *tulergi golo-be dasara jurgan* буюу хятадаар *li-fan-yuan*)-аас 1815 оны “гадаад муж”-д зориулан гаргасан хууль зүйлийн бичиг нь ноёнлон захирах ухаалаг бодлого байв уу?. *Acta Mongolica*. 2002. Tomus 1 (182). 149 дэх тал.

боловсруулахдаа ЗТГМТЗЯЯХЗБ-ийг шууд хуулбарлаагүй¹⁵, мөн түүхч Л.Алтанзаяа тус хоёр хуулийн “Лам нарын хэргийн хууль” хэмээх дэвтрүүдийг харьцуулж, дийлэнх нь шинээр бичсэн, ямар нэгэн нэмэлт өөрчлөлтийг их бага хэмжээгээр заавал оруулсан¹⁶ байна хэмээн тэмдэглэсэн байдаг нь энд харьцуулан судалсантай их төлөв дүйж байна.

VI. Дүгнэлт

МУХЗБ-ийг Манжийн ХЗБ-тэй харьцуулан судалсны үндсэнд дараах дүгнэлтэд хүрэв. МУХЗБ нь агуулгын хувьд Манжийн ХЗБ-ээс үндсээрээ ялгаатай байна. Харин хэлбэрийн буюу техникийн шинжээрээ төстэй буюу МУХЗБ-ийг боловсруулахдаа Манжийн ХЗБ-ийн хууль зүйн техникт голлон тулгуурлажээ. Энэ нь нэг талаас монголын уламжлалт хууль цаазын өөрийн нь өвөрмөц онцлог, нөгөө талаас Ази дорно дахины эрх зүйн соёлын нөлөө, бас өрнийн эрх зүйн тусгал, тэдгээрийг хослуулсан онцлог бүхий бие даасан хууль болсноор илрэлээ олж буй. МУХЗБ-ийг системчлэн боловсруулж, төрөлжүүлэн хуульчлахдаа Манжийн ХЗБ-ээс 30 дэвтрийн агуулгыг зохих хэмжээгээр өөрчилсөн */хэрэгцээгүй, шаардлагагүй зүйл заалтыг халах, хүчингүй болгох, монгол ахуй соёл хийгээд монголын нийгэм, улс төрийн нөхцөл байдалд тохируулан өөрчлөн найруулах, шинэ зүйл заалт нэмэх замаар/* бол 34 дэвтрийг шинээр тогтоожээ. МУХЗБ-ээр бие даасан, тусгаар тогтносон, бүрэн эрхт улсын улс төр, нийгэм, эдийн засаг, ахуй соёлын амьдралд нийцсэн хэм хэмжээг тогтоохыг гол болгож байсныг харьцуулсан судалгаанаас харж болохоор байна. Иймд МУХЗБ Манжийн ХЗБ-ийг хуулбарласан хууль биш гэдэг нь судалгааны үр дүнгээр нотлогдож байна. Цаашид МУХЗБ-ийн ихэнх хэм хэмжээг Манжийн ХЗБ-ээс өөрчлөн найруулж авсан гэдгийг залруулах шаардлагатай.

¹⁵ 島田正郎. 「ボクド=ゲケン=ホトクトの勅定法典」『清末における近代法典の偏版』. 1972.

¹⁶ Алтанзаяа, Л. Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг дэх Лам нарын хэргийн хуулийн тухай. “1911 оны Монголын үндэсний хувьсгалын түүхэн ач холбогдол: Үндэстний дуудлага, нөлөөлөл, хамаарал” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Уб., 2022. 159-160 дахь тал.

[Ном зүй]

Алтанзаяа, Л. Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг дэх Лам нарын хэргийн хуулийн тухай. “1911 оны Монголын үндэсний хувьсгалын түүхэн ач холбогдол: Үндэстний дуудлага, нөлөөлөл, хамаарал” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Уб., 2022

Болдбаатар, Ж., Лүндээжанцан Д. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Нэмж засварласан гурав дахь хэвлэл. Уб., 2021

Буянхишиг, Б. Хувийн эрх зүйн кодификац, онолын үндэс, тулгамдсан асуудал. Хууль зүйн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Уб., 2021

Нацагдорж, Ш., & Ишжамц, Н. (Ред.). Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх. Дэд боть. 1604-1917. Уб., 1968

Содовсүрэн, Б. Хувьсгалын өмнөх Монголын төр ба хууль цааз (1911-1920). Уб., 1989

Удо Б.Баркманн. Гадаад мужийг засах яам (манжаар *tulergi golo-be dasara jurgan* буюу хятадаар *li-fan-yuan*)-аас 1815 оны “гадаад муж”-д зориулан гаргасан хууль зүйлийн бичиг нь ноёнлон захирах ухаалаг бодлого байв уу?. *Acta Mongolica*. 2002. Tomus 1 (182).

МУУТА, Х-1, Д-1, Хн 290. 48-49.

Рязановский, В.А. Монгольское право (преимущественно обычное). Исторический очерк. Харбин, Китай. 1931

島田正郎. 「ボグド=ゲゲン=ホトクトの勅定法典」 『清末における近代法典の偏版』. 1972.

[Abstract]

**A Comparatives Study of the Manchu Legal Code
and the Jarliy-iyar toytayaysan mongyol ulus-un qauli
jüil-ün bičig (The Law of Mongolia enacted by Bogd
Khan's Edict /1911-1919/)**

Bayanbaatar Batbayar

Doctor of Laws (Ph.D.).

*Senior Lecturer at the Department of Public Law,
School of Law, National University of Mongolia*

Ulaanbaatar, Mongolia

This article presents a comparative study of the Manchu Legal Code and the Jarliy-iyar toytayaysan mongyol ulus-un qauli jüil-ün bičig (The Law of Mongolia enacted by Bogd Khan's Edict /1911-1919/). In drafting the The Law of Mongolia enacted by Bogd Khan's Edict, the Mongols did not place much emphasis on the content of the Manchu Legal Code, but skillfully adopted its structural format and legal techniques. As a sovereign and independent state, Mongolia gave priority to its traditional characteristics while formulating legal norms that reflected its own political, social, economic, and cultural realities. The findings of the comparative study reveal that, of the 65 volumes comprising the Law of Mongolia enacted by Bogd Khan's Edict, 30 were newly developed, and 34 were extensively revised based on legal techniques derived from the Manchu Legal Code. Only a few provisions were retained in their original form without modification.

[Keywords]

Manchu Legal Code, Jarliy-iyar toytayaysan mongyol ulus-un qauli jüil-ün bičig (The Law of Mongolia enacted by Bogd Khan's Edict /1911-1919/), structural comparison, content comparison, legal comparative study.